



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.04.29 № ХЭГ/838  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, авлига, хүнд суртлыг бууруулах "Шил" ажиллагааны хэрэгжилтийн талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3-оо хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000245008593

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД,  
НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, АВЛИГА, ХҮНД СУРТЛЫГ БУУРУУЛАХ  
"ШИЛ" АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

**Нэг. "ШИЛ" ажиллагааны үндэслэл**

Монгол Улсын Их Хурал 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэлэлцэн баталж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Уг хуулиар төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалтай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгах аргаар заасан.

Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг баталсан бөгөөд энэхүү журмаар мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийн сан үүсгэх, цахим хуудсанд байршуулж нийтлэх, нээлттэй мэдээлэл, цахим хуудсыг шинэчлэх, цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих харилцааг зохицуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/268, А/48 хамтарсан тушаалаар "Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам"-ыг баталж, зөвлөлийн үйл ажиллагаа, бүрэлдэхүүний эрх, үүрэг, хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах харилцааг зохицуулсан.

Түүнчлэн Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ыг баталсан бөгөөд уг журмаар мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг тогтоох, мөн хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг тус тус зохицуулсан болно.

"Шил ажиллагаа"-г хэрэгжүүлэх хүрээнд гарсан бусад тогтоол, шийдвэрүүдийг дурдвал:

1. "2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоол батлагдав.

2. Монгол Улсын Ерөнхий сайдын ажил хариуцуулах тухай 2023 оны 49 дүгээр захирамжаар "Шил ажиллагаа"-г Цахим хөгжил, харилцаа холбооны сайдад даалгасан.

3. 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр “Шил ажиллагаа”-ны хүрээнд мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн, хуульд заасан байнга нээлттэй, ил тод байх мэдээллийг нэгтгэн иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийнхэнд хялбар, нэг цонхоор мэдээлэл авах, хяналт тавих боломж бүхий shilen.gov.mn платформыг танилцуулж, нээлттэй, ил тод байдлыг шаардаж ажиллах тухай “Таны төр-Та хяна” уриалгыг олон нийтэд дэвшүүлэв.

4. Монгол Улсын Ерөнхий сайдын “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 2023 оны 01 дүгээр албан даалгавар гарсан.

5. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын “Штаб байгуулах тухай” 2023 оны А/32 дугаар тушаалаар 13 албан тушаалтны бүрэлдэхүүнтэй “Шил ажиллагаа”-ны багийг томилж, үйл ажиллагааны зохион байгуулалтын схемийг батлав.

6. “Шил ажиллагаа”-ны хэрэгжилтийн талаар Засгийн газрын хуралдаанаар нийт 4 удаа танилцаж, холбогдох төрийн байгууллагуудад тухай бүр чиглэл хүргүүлэн ажиллаж байна.

### **Хоёр. “ШИЛ” ажиллагааны хэрэгжилтийн талаар**

Дээр дурдсан тогтоол, шийдвэрүүдийн хүрээнд “Шил ажиллагаа”-ны хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор “shilen.gov.mn” цахим системийг ашиглалтад оруулж, үндэсний хэмжээнд “Шилэн индекс”-ийг зарлан, 14 удаагийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, иргэд, олон нийтийг нээлттэй мэдээллээр хангаж ажиллалаа.

“Шил ажиллагаа”-ны хүрээнд яам, агентлаг, аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 123 төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой мэдээлэл хариуцагч байгууллагатай холбогдож, info@shilen.gov.mn цахим шуудангаар 600 гаруй багц мэдээллийг хүлээн авч, “shilen.gov.mn” системд байршуулаад байна.

“Шил ажиллагаа”-ны “shilen.gov.mn” системийг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр ашиглалтад оруулснаас хойш 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 39 төрлийн 970,355 мэдээллийг байршуулж, 14,570,421 удаагийн хандалтыг аваад байна. Үүнд:

1. Улсын хэмжээнд нийт 123 улсын тусгай хамгаалалттай газар 36 хамгаалалтын захиргааны харьяалалд байна. Үүнээс Богдхан уулын дархан цаазат газар, Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын тусгай хамгаалалтын захиргааны 4568 га газрыг 78 байршилд 2079 хүн, хуулийн этгээдэд олгосон талаарх мэдээллийг;

2. Байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээний талаарх буюу 2008 оноос хойш хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад хийгдсэн ерөнхий үнэлгээний 10,812, нарийвчилсан үнэлгээний 4696, нийт 15,508 мэдээллийг;

3. Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2008 оноос хойш гарсан 8437 дүгнэлт, комисст ажилласан 135,102 албан хаагчийн мэдээллийг;

4. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой төлөөлөн удирдах зөвлөл бүхий 238 хуулийн этгээдийн 1634 төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэрс, цалингийн мэдээллийг;

5. Төрийн өмчийн 310 объектыг түрээсэлж байгаа 1572 түрээслэгчийн 2944 түрээсийн мэдээллийг;

6. Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар үйл ажиллагаа явуулж байгаа 24 тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 2008 оноос хойших мэдээллийг ил тод байршуулах ажлын хүрээнд:

6.1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас 2009-2022 оны хооронд нийт 8403 хүн, хуулийн этгээдэд олгосон 1 их наяд төгрөгийн зээлийн мэдээллийг жагсаалтын хамт;

6.2. Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 1994-2022 оны хооронд нийт 9387 хүн, хуулийн этгээдэд олгосон 207 тэрбум төгрөгийн зээлийн мэдээлэл болон 169.7 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдлийн талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

6.3. Улсын авто замын сангаас 2008-2023 оны хооронд нийт 107 хуулийн этгээдэд олгосон 540 төсөл, хөтөлбөрийн 220 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

6.4. Соёл, урлагийг дэмжих сангаас 2020-2022 оны хооронд нийт 219 хүн, хуулийн этгээдэд олгосон 6.5 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

6.5. Кино урлагийг дэмжих сангаас 2023 онд 11 хүн, хуулийн этгээдтэй байгуулсан 1 тэрбум төгрөгийн санхүүжилт, одоо хэрэгжиж байгаа гэрээний мэдээллийг жагсаалтын хамт;

6.6. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас 2012-2023 оны хооронд гэмт хэргийн хохирогч болсон 484 иргэнд олгосон 2.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, 1.6 тэрбум төгрөгийн авлагын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

6.7. Боловсролын зээлийн сангаас 2007-2023 оны хооронд нийт 1497 суралцагчид гадаадын зээл, тэтгэлгийн чиглэлээр олгосон 324 тэрбум төгрөгийн санхүүжилт, түүнээс 316 тэрбум төгрөгийн зээлийн мэдээллийг жагсаалтын хамт;

6.8. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас 2017-2023 оны хооронд давхардсан тоогоор 666 байгууллага, 18,477 суралцагчид олгосон 72.2 тэрбум төгрөгийн зарцуулалтын мэдээллийг жагсаалтын хамт;

6.9. Шинжлэх ухаан, технологийн сангаас 2007-2022 оны хооронд нийт 381 хүн, хуулийн этгээдэд олгосон 2780 төсөл, хөтөлбөрийн 151.9 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

6.10. Байгаль орчин, уур амьсгалын сангаас 2013-2022 оны хооронд 724 хүн, хуулийн этгээдэд олгосон 1095 төсөл, хөтөлбөрийн 17.7 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

6.11. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас 2009-2023 оны хооронд 2000 гаруй иргэнд олгосон 3.1 тэрбум төгрөгийн тусламжийн талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

6.12. Нийгмийн халамжийн сангийн 2008-2022 оны орлого, зарлагын мэдээлэл, мөн 2016-2022 оны хооронд хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настанд үзүүлсэн тусламж хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлдэг 1003 хуулийн этгээдэд олгосон санхүүжилтийн мэдээллийг жагсаалтын хамт;

6.13. Нийгмийн даатгалын сангийн 2008-2022 оны орлого, зарлагын мэдээлэл, мөн 2010-2020 оны хооронд банканд байршуулсан мөнгөн хөрөнгийн дүн, хүүгийн орлогын мэдээллийг жагсаалтын хамт;

6.14. Хүүхдийн төлөө сангийн 2021-2023 оны хооронд нийт 11 тэрбум төгрөгийн хуримтлалыг үүсгэж, үүнээс 106.7 сая төгрөгийг нийт 45 хүүхдэд хоёр зориулалтаар зарцуулсан талаарх мэдээллийг;

6.15. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2012-2022 оны хооронд давхардсан тоогоор 1.8 сая иргэнд 628.7 тэрбум төгрөгийн зарцуулалт хийсэн ба үүний 122.2 тэрбум төгрөг нь санхүүгийн дэмжлэг хэлбэрээр олгогдож, нийт 58.2 тэрбум төгрөгийн авлагатай байгаа талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

6.16. Ирээдүйн өв сангийн 2017-2022 оны орлого, зарлагын мэдээллийг;

6.17. Төсвийн тогтворжуулалтын сангийн 2011-2022 оны орлого, зарлагын мэдээллийг;

6.18. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018-2022 оны орлого, зарлагын мэдээллийг жагсаалтын хамт (тус сан нь 2018 оноос өмнө Нийгмийн даатгалын сангийн бүрэлдэхүүн хэсэг байсан тул 2008-2018 оны орлого, зарлагын мэдээллийг Нийгмийн даатгалын сангийн хэсгээс харах боломжтой);

6.19. Эрүүл мэндийг дэмжих сангаас 2008-2023 оны хооронд нийт 658 хуулийн этгээдэд 28.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон мэдээллийг жагсаалтын хамт;

6.20. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2009-2022 оны хооронд 484 хуулийн этгээдээс нийт 47.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлж, 155 төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд 38.6 тэрбум төгрөг зарцуулсан талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

6.21. Спортын дэмжих сангаас 2017-2019 оны хооронд нийт 57 хуулийн этгээдэд олгосон 66 төсөл, арга хэмжээний 4.9 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг;

7. Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан 2008 оноос хойших шийдвэрийн талаар Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас ирүүлсэн 126,857, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас ирүүлсэн 41,956 газрын мэдээллийг жагсаалтаар;

8. 18 байгууллагаас олгодог 14,344 зөвшөөрөл болон ашигт малтмалын 885 хайгуулын, 1713 ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээллийг жагсаалтаар тус тус нээлттэй мэдээллийн систем “shilen.gov.mn”-д байршуулсан байна.

Түүнчлэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй мэдээллийг 98 шалгуур үзүүлэлтээр долоо хоног бүр үнэлж “Шилэн индекс”-ийг зарласан. Үүнд:

- Төрийн захиргааны төв 16 байгууллагын хувьд дундаж үзүүлэлт 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 66.1 хувь байсан бол 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 96.8 хувь,
- Төрийн захиргааны 40 байгууллагын хувьд дундаж үзүүлэлт 2023 оны 04 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 51 хувь байсан бол 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 79.3 хувь,
- Нутгийн захиргааны байгууллагуудын хувьд дундаж үзүүлэлт 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 43 хувь байсан бол 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 91 хувь,
- Нийслэлийн 9 дүүргийн хувьд дундаж үзүүлэлт 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 57 хувь байсан бол 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 96 хувь,
- Бусад 37 байгууллагын хувь дундаж үзүүлэлт 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 37 хувьтай тус тус үнэлэгдээд байна.

2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр нээлттэй мэдээллийн систем “shilen.gov.mn”-ийн 2.0 хувилбарыг хөгжүүлж, хувийн хэвшилтэй хамтран хиймэл оюуны сүүлийн үеийн технологи (GPT)-ийг ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд сургаж, нэвтрүүлсэн.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн цуглуулж, боловсруулж, байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг тухайн мэдээлэл хариуцагч байгууллагын албан хаагч тоон гарын үсгээр нэвтэрч системд байршуулах, улмаар үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах, өөрийн байгууллагын “Шилэн индекс”-ийн үнэлгээний мэдээллээ тусгах, дээд шатлалын байгууллага хянаснаар дараа системд нээлттэй нийтлэгдэх боломжийг тус тус бүрдүүлээ.

Мэдээллийн хариуцагч байгууллагын нээлттэй мэдээлэл хариуцсан албан хаагчдад “shilen.gov.mn” системийн 2.0 хувилбарт хэрхэн мэдээлэл байршуулах талаар сургалтыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.

-----oOo-----



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИАР ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 2008 ОНООС ХОЙШИХ МЭДЭЭЛЛИЙГ "ШИЛ АЖИЛЛАГАА"-НЫ SHILEN.GOV.MN СИСТЕМД ИЛ ТОД БАЙРШУУЛСАН БАЙДАЛ**

2024.04.19

Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн хуульд 24 тусгай санг баталсан. Үүнээс Боловсролын зээлийн сан, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Кино урлагийг дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Шинжлэх ухаан, технологийн сан гэсэн 6 тусгай сан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Эдгээрээс Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай болох нь тогтоогдсон этгээдээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, нөхөн төлүүлдэг онцлогтой. Түүнчлэн Хөдөө аж ахуйг дэмжих сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр "Тусгай сан"-ийн жагсаалтаас хасагдаж Хөдөө аж ахуйн корпорац болсон. Дараах хүснэгтээс тусгай сангуудын мэдээллийг дэлгэрэнгүй оруулав. Үүнд:

№	ЗГ-ЫН ТУСГАЙ САНГИЙН НЭР	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ ЭХЭЛСЭН ОН	SHILEN.GOV.MN СИСТЕМД БАЙРШСАН МЭДЭЭЛЭЛ			ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ САНХҮҮЖИЛТ ОЛГОДОГ ЭСЭХ	
			Мэдээллийн хугацаа	Мэдээлэл /2024.04.19-ны байдлаар/	Анх нийтлэгдсэн огноо	Тийм/үгүй	Тайлбар /Хууль зүйн заалт/
1.	Байгаль орчин, уур амьсгалын сан	2012 /ЗГ-ын 2012 оны 189 дүгээр тогтоолоор "Байгаль Хамгаалах Сан"-ийн байгуулалт, орон тооны хязгаарыг шинэчлэн баталж бие даан үйл ажиллагаа явуулж эхэлсэн.	2013-2022	724 хүн, хуулийн этгээдэд олгосон 1,091 төсөл, хөтөлбөрийн 17.7 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;	2023.04.03	Үгүй	<p>Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт заасан арга хэмжээг эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр санхүүжүүлдэг.</p> <ul style="list-style-type: none"> <li>7.3.1.байгалийн баялгийн нөөц, байгаль орчны төлөв байдлын хувьсал, өөрчлөлтийн байдлыг судлан тогтоох, мэдээллийг хуримтлуулж боловсруулах, дүгнэлт гаргах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;</li> <li>7.3.2.байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг багасгах дэвшилтэт арга, хоргүй, бохирдолгүй, хаягдалгүй, эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг урамшуулах;</li> <li>7.3.3.хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах;</li> </ul>



№	ЗГ-ЫН ТУСГАЙ САНГИЙН НЭР	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ ЭХЭЛСЭН ОН	SHILEN.GOV.MN СИСТЕМД БАЙРШСАН МЭДЭЭЛЭЛ			ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ САНХҮҮЖИЛТ ОЛГОДОГ ЭСЭХ
			Мэдээллийн хугацаа	Мэдээлэл /2024.04.19-ны байдлаар/	Анх нийлгэгдсэн огноо	
		болгон өөрчлөн байгуулсан./			Тийм/үгүй	Тайлбар /Хууль зүйн заалт/ <ul style="list-style-type: none"><li>7.3.4.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 56 дугаар зүйлд заасан экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг дэмжих;</li><li>7.3.5.хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгахад шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардлыг санхүүжүүлэх;</li><li>7.3.6.уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийг бууруулахад дэмжлэг үзүүлэх;</li><li>7.3.7.ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах;</li><li>7.3.8.агаар, орчны бохирдлыг бууруулах нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</li><li>7.3.9.мэрэгч, хөнөөлт хортон шавж устгах;</li><li>7.3.10.усыг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх;</li><li>7.3.11.байгалийн гамшигт үзэгдлээс учирч болох эрсдэлийг бууруулах чиглэлээр олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, танин мэдэхүйн үйл ажиллагааг дэмжих.</li><li>7.3.12.генетик нөөцийг тогтоох, судлах, хамгаалах, нөхөн сэргээх, генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, гений санг хөгжүүлэх.</li></ul>
2.	Боловсрол ын зээлийн сан	1993 /Шинжлэх ухаан боловсролын яамны "Сургалтын төрийн сан"-г анх байгуулжээ. МУ-ын ЗГ-ын 1992 онд 107 дугаар тогтоол батлагдаж	2008-2023	Нийт 1497 суралцагчид 324.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Үүнээс 1,308 суралцагчид 316.1 тэрбум төгрөгийн гадаадын зээл,	2023.05.22	Тийм Засгийн газрын тусгай сангийн тухай хууль: 8.3.Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг Засгийн газраас баталсан журмын дагуу иргэдэд олгох сургалтын төлбөрийн зээл, хуулиар тогтоосон бусад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ болон сангийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.





№	ЗГ-ЫН ТУСГАЙ САНГИЙН НЭР	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ ЭХЭЛСЭН ОН	SHILEN.GOV.MN СИСТЕМД БАЙРШСАН МЭДЭЭЛЭЛ			ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ САНХҮҮЖИЛТ ОЛГОДОГ ЭСЭХ	
			Мэдээллийн хугацаа	Мэдээлэл /2024.04.19-ны байдлаар/	Анх нийтлэгдсэн огноо	Тийм/үгүй	Тайлбар /Хууль зүйн заалт/
3.	Бүх нийтийн үйлчилгээн ий үүргийн сан	2009 улс, аймаг, орон нутгийн захилгаар улсын зээлээр суралцаж дээд боловсрол эзэмших юм./	2009-2022	189 суралцагчид 7.9 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон мэдээллийг жагсаалтын хамт; 484 хуулийн эгтгээдээс нийт 47,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлж, 155 төсөл, хөтөлбөрийн санхүүжүүлэлтэд 38.6 тэрбум төгрөг зарцуулсан талаарх мэдээллийг жагсаалтын хамт;	2023.05.29	Үгүй	Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан дараах арга хэмжээг эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр санхүүжүүлдэг. <ul style="list-style-type: none"><li>9.1. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх зориулалттай байна.</li><li>9.4. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгийг энэ хуулийн 9.1-д заасан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.</li></ul>
4.	Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан	2012	2012-2023	Гэмт хэргийн хохирогч болсон 468 иргэнд олгосон 2.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, 1,6 тэрбум төгрөгийн авлагын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;	2023.05.26	Тийм	Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан дараах арга хэмжээг санхүүжүүлдэг. <ul style="list-style-type: none"><li>10.3. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл /Хүнийг алах/, 11.1 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.4 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/, 13.2 дугаар зүйл /Хүн хулгайлах/, 13.3 дугаар зүйл /Хүн барьцаалах/, 13.4 дүгээр зүйл /Хүнийг хүчээр алга болгох/, 15.3 дугаар</li></ul>



№	ЗГ-ЫН ТУСГАЙ САНГИЙН НЭР	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ ЭХЭЛСЭН ОН	SHILEN.GOV.MN СИСТЕМД БАЙРШСАН МЭДЭЭЛЭЛ		ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ САНХҮҮЖИЛТ ОЛГОДОГ ЭСЭХ	
			Мэдээллийн хугацаа	Мэдээлэл /2024.04.19-ны байдлаар/		
			Мэдээлэл /2024.04.19-ны байдлаар/	Анх нийтлэгдсэн огноо	Тайлбар /Хууль зүйн заалт/  зүйл /Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах/, 15.5 дугаар зүйл /Хууль бусаар үр хөндөх/, 16.1 дүгээр зүйл /Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах/, 16.3 дугаар зүйл /Хүүхдийг хаях, теөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх/, 16.6 дугаар зүйл /Хүүхэд худалдах/, 16.7 дугаар зүйл /Хүүхэдтэй хэрцгий харьцах/, 16.11 дүгээр зүйл /Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 19.3 дугаар зүйл /Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/, 29.1 дүгээр зүйл /Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/, 29.8 дугаар зүйл /Террорист үйлдэл хийх/-д заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохилогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дараах хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна: ○ 10.3.1.эмчилгээний зардал; ○ 10.3.2.оршуулгын зардал; ○ 10.3.3.хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого.	
5.	Жижиг, дунд үйлдвэрлэ лийг хөгжүүлэх сан	2009	2009-2022	Нийт 8,403 хүн, хуулийн этгээдэд олгосон 1 их наяд төгрөгийн зээлийн мэдээлэл, үлдэгдлийн талаарх мэдээллийг жагсаалтын хамт;	2023.04.24  Тийм	Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан дараах арга хэмжээг санхүүжүүлдэг.  ■ 16.1.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зориулалттай байна. ■ 16.5.Энэ хуулийн 16.4-т заасан эх үүсвэрийг тухайн орон нутгийн энэ хуулийн 16.1-д заасан арга хэмжээнд зарцуулна.



№	ЗГ-ЫН ТУСГАЙ САНГИЙН НЭР	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ ЭХЭЛСЭН ОН	SHILEN.GOV.MN СИСТЕМД БАЙРШСАН МЭДЭЭЛЭЛ			ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ САНХҮҮЖИЛТ ОЛГОДОГ ЭСЭХ	
			Мэдээллийн хугацаа	Мэдээлэл /2024.04.19-ны байдлаар/	Анх нийтлэгдсэн огноо	Тийм/үгүй	Тайлбар /Хууль зүйн заалт/
							<ul style="list-style-type: none"><li>■ 16.6.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:<ul style="list-style-type: none"><li>○ 16.6.1.жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох;</li><li>○ 16.6.2.жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид бүтээгдэхүүнээ экспортод гаргасан бол зээлийн хүүгийн татаас олгох;</li><li>○ 16.6.3.жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд бизнес, инкубацийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, сургалт, давтан сургалтад хамруулах;</li><li>○ 16.6.4.жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх;</li><li>○ 16.6.5.жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;</li><li>○ 16.6.6.шаардлагатай тохиолдолд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан жижиг, дунд үйлдвэрийг дэмжихэд чиглэсэн тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх;</li><li>○ 16.6.7.энэ хуулийн 24.7-д заасан үйл ажиллагааг санхүүжүүлэх;</li><li>○ 16.6.8.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үндсэн болон өр барагдуулахтай холбогдсон үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэх.</li></ul></li></ul>
6.	Засгийн газрын нөөц сан	-	-	-	Үгүй	Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дугаар зүйлд заасан дараах арга хэмжээг санхүүжүүлдэг. <ul style="list-style-type: none"><li>■ 11.5.Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.</li></ul>	



ШИЛ АЖИЛЛАГАА

SHILEN.GOV.MN

№	ЗГ-ЫН ТУСТАЙ САНГИЙН НЭР	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ ЭХЭЛСЭН ОН	SHILEN.GOV.MN СИСТЕМД БАЙРШСАН МЭДЭЭЛЭЛ			ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ САНХҮҮЖИЛТ ОЛГОДОГ ЭСЭХ
			Мэдээллийн хугацаа	Мэдээлэл /2024.04.19-ны байдлаар/	Анх нийтлэгдсэн огноо	
						<p>Тайлбар /Хууль зүйн заалт/</p> <ul style="list-style-type: none"><li>11.5.1.Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах, эрсдэлийг бууруулах;</li><li>11.5.2.Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс барилга байгууламж, шугам, сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх, тээврийн хэрэгсэл сүйрэх, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгах;</li><li>11.5.3.алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирсан хохирлыг арилгах;</li><li>11.5.4.энэ хуулийн 11.1-д заасан арга хэмжээг санхүүжүүлэхтэй холбоотой төсвийн жилийн дундуур баталсан Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх;</li><li>11.5.5.Засгийн газар олон улсын шүүх, арбитраг хариуцагчаар татагдсан буюу тэдгээрээс гарсан шийдвэрийг биелүүлэхэд шаардагдах зардлыг хариуцах;</li><li>11.5.6.олон улсын гэрээний дагуу Монгол Улс төлж барагдуулах тухайн жилийн төсөвт тусгагдаагүй татвар, төлбөр, хураамжийг төлөх.</li><li>11.5.7.ээлжит бус, дахин, нөхөн сонгууль, ард нийтийн санал асуулга явуулахад шаардагдах зардал.</li></ul>
7.	Зэвсэгт хүчний хөгжлийн сан	2010				Төрийн болон албаны нууцад хамаардаг



№	3Г-ЫН ТУСГАЙ САНГИЙН НЭР	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ ЭХЭЛСЭН ОН	SHILEN.GOV.MN СИСТЕМД БАЙРШСАН МЭДЭЭЛЭЛ			ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ САНХҮҮЖИЛТ ОЛГОДОГ ЭСЭХ	
			Мэдээллийн хугацаа	Мэдээлэл /2024.04.19-ны байдлаар/ мэдээллэйг;	Анх нийтлэгдсэн огноо		Тийм/үгүй
8.	Ирээдүйн өв сан	2017	2017-2022	Орлого, зарлагын мэдээллэйг;	2023.05.29	Тийм/үгүй	Тайлбар /Хууль зүйн заалт/  Ирээдүйн өв сангийн хуулийн дагуу 2017-2019 онуудад тус санд төвлөрсөн эх үүсвэрээс улсын төсөвт 310.0 тэрбум төгрөгийг шилжүүлж, мөн Хүний хөгжил сангийн хуримтлагдсан өр төлбөр болох 1,071.9 тэрбум төгрөгийг бүрэн барагдуулснаар 2019 онд анх удаа байгалийн баялгаас олсон орлогоос хуримтлал үүсгэсэн болно. 2022 оны жилийн эцсийн байдлаар хуримтлал 2,618.1 тэрбум төгрөг байна. Ирээдүйн өв сангийн тухай хуулиар тус сангийн хөрөнгийг 2025 он хүртэл Сангийн яам төрийн сангийн хөрөнгө дансыг удирдах, мөнгөн хөрөнгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд хуримтлуулж байхаар заасан бөгөөд хуульд заасны дагуу Ирээдүйн өв сангаас 2030 он хүртэл сангийн хөрөнгийг удирдахтай холбоотой зардал болон хөндлөнгийн аудитын зардлыг санхүүжүүлэхээс бусад байдлаар зарцуулалт хийхгүй болно.
9.	Кино урлагийг дэмжих сан	2022	2023	Нийт 11 хүн, хуулийн этгээдтэй байгуулсан 1 тэрбум төгрөгийн санхүүжилт, одоо хэрэгжиж байгаа гэрээний мэдээллийг жагсаалтын хамт;	2023.05.26	Тийм	Кино урлагийг дэмжих тухай хууль: 13.1.Кино урлагийг дэмжих сангийн эргэн төлөх нөхцөлгүй олгох санхүүжилтийг дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд олгоно: <ul style="list-style-type: none"><li>13.1.1.монголын түүх, соёл, ахуй амьдралыг харуулах, эсхүл хүүхэд, залуучуудын хүмүүжил, төлөвшил, нийгмийн эрүүл мэнд, эрүүл, зөв амьдрах дадал зуршил хэвшүүлэхэд эергээр нөлөөлөх, эсхүл олон улсын кино наадамд өрсөлдөх зорилготой найруулагчийн хувийн бүтээлч чанар, гоо зүйн үнэлэмж, үзэл бодлын илэрхийллийг харуулсан кино бүтээх;</li><li>13.1.2.монгол киног хадгалах, сэргээн хөрвүүлэх;</li><li>13.1.3.олон улсын кино наадам, үзэсгэлэнд монгол киногоор оролцох, Монгол Улсад олон улсын кино наадам зохион байгуулах;</li></ul>



№	ЗГ-ЫН ТУСГАЙ САНГИЙН НЭР	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ ЭХЭЛСЭН ОН	SHILEN.GOV.MN СИСТЕМД БАЙРШСАН МЭДЭЭЛЭЛ			ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ САНХҮҮЖИЛТ ОЛГОДОГ ЭСЭХ	
			Мэдээллийн хугацаа	Мэдээлэл /2024.04.19-ны байдлаар/	Анх нийтлэгдсэн огноо		
10.	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сан	2011	2017-2023	Давхардсан тоогоор 666 байгууллага болон 18477 суралцагчид олгосон 72.2 тэрбум төгрөгийн зарцуулалтын мэдээллийг жагсаалтын хамт;	2023.05.31	Үгүй	Тайлбар /Хууль зүйн заалт/ <ul style="list-style-type: none"><li>13.1.4. кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.</li><li>13.2. Кино урлагийг дэмжих сангийн эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээлийг дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд олгоно:<ul style="list-style-type: none"><li>13.2.1. энэ хуулийн 13.1.1-д зааснаас бусад кино бүтээх;</li><li>13.2.2. кино үйлдвэрлэлд шаардлагатай дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн техник технологи, программ хангамж, инновац нэвтрүүлэх.</li></ul></li></ul> Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль; 29.4. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулна: <ul style="list-style-type: none"><li>29.4.1. өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилт;</li><li>29.4.2. төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрын тогтмол зардал, суралцагчийн хоолны зардал;</li><li>29.4.3. өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгох тэтгэлэг, бусад дэмжлэг;</li><li>29.4.4. нэг суралцагчид ногдох мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан дундаж норматив зардал;</li><li>29.4.5. багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт, мэргэшүүлэх сургалтын зардал;</li></ul>



№	ЗГ-ЫН ТУСТАЙ САНГИЙН НЭР	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ ЭХЭЛСЭН ОН	SHILEN.GOV.MN СИСТЕМД БАЙРШСАН МЭДЭЭЛЭЛ		ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ САНХҮҮЖИЛТ ОЛГОДОГ ЭСЭХ		
			Мэдээллийн хугацаа	Мэдээлэл /2024.04.19-ны байдлаар/		Анх нийтлэгдсэн огноо	Тийм/үгүй
11.	Нийгмийн даатгалын сан		2008-2022	Орлого, зарлагын мэдээллийг, 2010- 2020 оны банканд байршуулсан мөнгөн хөрөнгийн дүн, хүүгийн орлогын мэдээллийг жагсаалтын хамт.	2023.05.22	Үгүй	29.4.6.мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний зардал; 29.4.7.энэ хуулийн 26.1-д заасан байгууллагын үйл ажиллагааны зардал; 29.4.8.мэргэжлийн ур чадварын олон улсын хэмжээний тэмцээнд бэлтгэх, оролцох, урамшуулах зардал болон үндэсний хэмжээний мэргэжлийн ур чадварын тэмцээнийг зохион байгуулах зардал. Нийгмийн даатгалын тухай хууль
12.	Нийгмийн халамжийн сан		2008-2022	Орлого, зарлагын мэдээллийг, 2016- 2022 оны хооронд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт, ахмад настанд үзүүлсэн тусламж хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг	2023.05.08	Үгүй	Нийгмийн халамжийн тухай хууль



№	ЗГ-ЫН ТУСГАЙ САНГИЙН НЭР	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ ЭХЭЛСЭН ОН	SHILEN.GOV.MN СИСТЕМД БАЙРШСАН МЭДЭЭЛЭЛ			ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ САНХҮҮЖИЛТ ОЛГОДОГ ЭСЭХ	
			Мэдээллийн хугацаа	Мэдээлэл /2024.04.19-ны байдлаар/	Анх нийтлэгдсэн огноо	Тийм/үгүй	Тайлбар /Хууль зүйн заалт/
